

**УЛСЫН ХИЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ БА
ХҮНИЙ АЮУЛГҮЙ БАЙДАЛ**

М.БАТМӨНХ

ХСИС-ийн Хууль сахиулахын удирдлагын академийн
8042 дугаар дамжааны суралцагч, хошууч;

В.Пүрэвбаасан

ХСИС-ийн Хууль сахиулахын удирдлагын академийн
Хилийн албаны удирдлага, стратегийн профессорын
багийн дэд профессор, хурандаа

Хураангуй: Хүний аюулгүй байдал хангагдсанаар улсын хилийн аюулгүй байдалд нөлөөлөх нь.

Түлхүүр үг: Аюулгүй байдал, аюул, хилийн аюулгүй байдал, хүний аюулгүй байдал.

Аюулгүй байдлын тухай ойлголт

Даяарчлагдаж буй өнөөгийн үед олон улсын түвшинд аюулгүй байдал хэмээх ойлголтын талаар ихээр ярьж, бичих болсон билээ. Тэгвэл аюулгүй байдал гэж чухам юу вэ? гэсэн асуулт гарч байна. Энэ талаар судлаачид олон янзаар тайлбарлан аюулгүй байдлын талаарх мэдлэг аюулгүй байдлын сургаалиас өнөөдөр шинжлэх ухааны түвшинд судлагдах хүртлээ хөгжжээ.

Хүн төрөлхтний хамгийн суурь асуудал нь аюулгүй байдал байсаар ирсэн төдийгүй, аюулгүй байдлын түвшин өнөөдөр хамгийн бага, энгийн зүйлээс эхлээд дэлхий нийт, сансар огторгуйн хэмжээнд хүртлээ өргөжин тэлсэн байна.

Эрт цагт “аюулгүй байдал” гэдгийг гадны аливаа аюул хөнөөлөөс найдвартай хамгаалагдаж, оюун санааны хувьд тайван байх явдал гэж ойлгодог байжээ.¹

Хүн төрлөхтөн анх үүсч бий болон нийгмийн түүхэн хувьсалын аль ч цаг үеүүдэд хувь хүн, гэр бүл, овог аймаг, цаашлаад үндэстэн, улс гүрэн, газар нутгийнхаа хэрэгцээ, эрх ашиг сонирхлыг хамгаалах асуудал, аюул заналхийлэлгүй орших шаардлага зүй ёсоор тавигдаж байсан байдаг.

Улс орнууд аюулгүй байдал хэмээх ойлголтыг улсын хил хязгаарт заналхийлэлтэй тэмцэх, эдийн засгийн аюулгүй байдлыг бэхжүүлэх, хүн амын удмын санг хамгаалах, түүгээрч барахгүй хоол хүнс, экологи, соёл зэрэг салбарын асуудлын хүрээнд авч үзэж ирсэн байдаг.

Эрдэмтэн судлаачид “Аюулгүй байдал” гэдэг ерөнхий ойлголтыг янз бүрээр тайлбарласан байдаг. Энэ ойлголт тодорхой тохиолдолд субъектын аюулгүй байдлын өвөрмөц онцлогийг илэрхийлэхийн зэрэгцээ, олон салбарт хэрэглэж болох нийтлэг утгыг агуулж байдаг.

Аюулгүй байдлын талаарх ойлголтыг Британика нэвтэрхий тольд “Аюулгүй байдал-амар тайван, бат бэх, итгэлтэй байх нөхцөл байдал. аюул болон эрсдэлээс чөлөөтэй байх”, Оксфордын Англи хэлний тольд “Аюулгүй байдал-амар тайван, бат бэх, итгэлтэй нөхцөл” гэсэн бол Я.Цэвэлийн Монгол хэлний тайлбар тольд “Аймаар юмгүй, айх болгоомжлох шаардлагагүй” гэж тайлбарлажээ. Мөн аюулгүй байдал гэж гамшиг, зовлон учруулж байдаг хор хөнөөлтэй зүйл¹, харин аюулгүй байдал гэж айвал зохих бэрх хэцүү байдал, хор уршиг, хөнөөл учирч болох байдал, заналхийлж буй байдал ^{1 2} хэмээн манай эрдэмтэн, судлаачид тайлбарласан байдаг бол олон улсад “аюулгүй байдал гэдэг нь хүн, нийгэм, төрийн амин чухал ашиг сонирхол хамгаалагдсан байдал юм” гэж нийтлэг байдлаар тодорхойлдог байна.

“Аюулгүй байдал нь тухайн улсад улс төрийн, эдийн засгийн ба нийгэмшлийн тогтвортой байдлыг тогтоон хангах, хуулиудыг чанд сахин биелүүлэх, эрх зүйн дэг журмуудыг хангуулах, олон улсын хамтын үйл ажиллагааг хөгжүүлэх үндэс болсон улс төрийн, эдийн засгийн, нийгмийн, цэргийн, экологийн, мэдээллийн бусад шинж чанартай аюул заналхийллээс бие хүн, нийгэм, төрийн амин чухал ашиг сонирхол хамгаалагдсан байдал”³ хэмээн манай нэрт хуульч академич С.Нарангэрэл тодорхойлжээ.

Аливаа зүйл, шинжлэх ухаан, техник технологийн хувьсал, өөрчлөлт, хөгжил нь нэг талаараа өөртөө ямар нэг давуу байдлуудыг агуулж байдаг боловч нөгөө талаараа шинэ аюул заналыг дагуулсаар байдаг. Энэхүү шинээр илрэн гарч буй аюул заналаас зайлсхийх үйл ажиллагааг өөр арга хэлбэрээр авч хэрэгжүүлэх шаардлага урган гарч, түүнийг хэрэгжүүлж байгаа байдал нь өөрөө аюулгүй байдлын хөгжлийг дагуулж байна.

Улсын хилийн аюулгүй байдлын талаарх ойлголт

Улс үндэстний аюулгүй байдлын тухай ойлголт түүхийн хөгжил дэвшил, нийгмийн өөрчлөлт, шинэчлэлтийн аясаар өөрчлөгдөж байдаг. Монгол улс ардчилсан эрх зүйт нийгмийг сонгон шинэ “Үндсэн хууль”-нараа баталгаажуулсан нь нийгмийн бүхий л салбарт өөрчлөлт шинэчлэлт хийх шаардлага зүй ёсоор тулгарч, Социалист системийн үеийн аюулгүй байдлаа хангах асуудал хуучирч, улс орны аюулгүй байдлыг хангах асуудал шинэ утга

¹ Цэвэл Я, Монгол хэлний товч тайлбар толь, УБ.. 1966. 66 дахь тал.

² Даш Н нар Монгол хэлний тайлбар толь, УБ.. 2014, 92 дахь тал.

³ Нарангэрэл С, Эрх зүйн эх толь бичиг, УБ., 2008, 54 дэх тал.

агуулгаар тодорхойлогдох болж Монгол улс аюулгүй байдлаа бие даан хангах шаардлага бий болсон юм.

Дэлхий нийтэд өрнөсөн даяаршил, нийгэм, улс төрийн байдал, манай орны гадаад дотоод бодлого нь улсын хилийн аюулгүй байдал, хил хамгаалалтын асуудалд шинжлэх ухааны үүднээс хандахын чухлыг харуулж байна. Орчин үеийн дэлхий ертөнцөд гарч буй томоохон өөрчлөлтүүд, хил дамнасан гэмт хэрэг, нийгэм эдийн засгийн хямрал зэргээс үүдэн гарч буй сөрөг үзэгдлүүд нь улсын хил, түүний орчинд хурцаар илэрч Монгол Улсын үндэсний аюулгүй байдалд бодитойгоор нөлөөлөх болов.

Монгол улсын Үндсэн хуулийн нэгдүгээр зүйлийн 1-д “Монгол Улс бол тусгаар тогтносон, бүрэн эрхт, Бүгд найрамдах улс мөн”, дөрөвдүгээр зүйлийн 1-д “Монгол Улсын нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, улсын хил халдашгүй дархан байна”, Монгол Улсын Их хурлын 48-р тогтоолоор батлагдсан Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 1.1.2-д “Монгол Улсын үндэсний язгуур ашиг сонирхолд монголын ард түмэн, соёл иргэншил оршин тогтнох, Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэр, хил хязгаарын халдашгүй байдал болон бүрэн бүтэн байдал, үндэсний эв нэгдэл, үндсэн хуульт байгууллын аюулгүй байдал, эдийн засгийн бие даасан байдал, экологийн тэнцвэрт хөгжил багтана.”, гуравдугаар бүлэгт “Оршин тогтнохын аюулгүй байдлын үндэс нь “Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, хил хязгаарын халдашгүй байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал юм” гэжээ. Улсын Их Хурлаас баталсан “Монгол Улсын төрөөс хилийн талаар баримтлах бодлого” баримт бичигт “Хилийн талаар баримтлах бодлого нь байгууллага, иргэдийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулах замаар улсын хилийн халдашгүй байдал, хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдлыг хангахад чиглэнэ” гэж заасан.

Монгол улс хэдийгээр далайд гарцгүй, эх газрын улс боловч дэлхий дахин болон бүс нутагт тэргүүлэгч нөлөө бүхий хүчирхэг хоёр их гүрэнтэй хил залган оршдог, аюулгүй байдал нь дээрх улс орнуудаас хамааралтай төдийгүй эдгээр улсуудын нөлөөгөөр тогтвортой байх, тогтворгүй байх нь шууд шалтгаалах эмзэг орчинд оршин тогтнож байна. Иймд улсын хилийн аюулгүй байдал судлаачдын анхаарлын төвд зайлшгүй байх шаардлага урган гарч байна.

Монгол улсын Хилийн тухай хуулийн 5 дугаар зүйлд “Монгол Улсын хилийн аюулгүй байдал нь /цаашид “хилийн аюулгүй байдал” гэх/ Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын салшгүй хэсэг мөн.

Хилийн аюулгүй байдал гэж улсын хил, хил орчмын нутаг дэвсгэрт үндэсний язгуур ашиг сонирхлыг хангах, гадаад, дотоод таатай нөхцөл баталгаатай хангагдсаныг хэлнэ” гэж заажээ.

Үүнээс харахад хилийн аюулгүй байдлыг хангах гол зорилго нь хилийн орчмын нутаг дэвсгэрт Монгол Улсын үндэсний язгуур ашиг сонирхлыг гадаад, дотоодын аюул, заналаас хамгаалах төр, нийгэм, иргэний аюулгүй байдлыг хангахдаа юуны урьд хилийн талаар байгуулсан олон улсын гэрээ хэлэлцээр, эрх зүйн хэм хэмжээг сахих, зэргэлдээ улстай хамтын ажиллагааг хөгжүүлэх бүх талын бололцоо олгоход оршиж байна.

Хүний аюулгүй байдлын талаарх ойлголт

Дэлхийн улс орнуудад даяарчлалын үйл явц эрчимтэй өрнөж буй энэ цаг үед НҮБ-ын хөгжлийн хөтөлбөрт аюулгүй байдлын гол цөм нь улс гүрэн бус харин хувь хүн байх учиртайг онцолсноор “Хүний аюулгүй байдал” өнөөдөр дэлхийн хэмжээний бодлогын түлхүүр үзэл баримтлал болсон.

Аюулгүй байдал гэдэг нь хүн нийгэм, төрийн амин чухал ашиг сонирхол хамгаалагдсан байх явдал гэж нийтлэг тайлбарладаг бол хүний аюулгүй байдал нь дайн, зэвсэг, мөргөлдөөн биш харин хүний өдөр тутмын амьдрал, хүн ёсоор амьдрахтай холбоотой ойлголт юм.

Хүн аюулгүй байхын тулд аюулгүй байдлаа хангах гарцаагүй шаардлага бий болсоор байна.

Нийгмийн ямар ч тогтолцоо оршин тогтнож байсан хүмүүс нийгмийн материал баялагийг бүтээж, төр улсыг өөрсдийнхөө аюулгүй байдлыг хангах хүч хэрэгсэл болгон байгуулж, зарим үед нэгдэн нийлж заримдаа хоорондоо дайсагналцаж иржээ. Одоо үед ч гэсэн хүмүүсийн бодлогогүй буруу үйлдэл, ажиллагаанаас дэлхийн байгаль, цаг уурын тэнцэл алдагдаж, дэлхий нийтийг хамарсан байгалийн гамшиг, аж үйлдвэрлэлтээс үүдэлтэй орчны бохирдол, ДОХ мэтийн халдварт өвчин гарч, үндэстэн дамнасан гэмт явдал, терроризм, зарим бүс нутагт улс, үндэстний хооронд дайн үүсч, улс орнуудын тусгаар тогтнол, хилийн аюулгүй байдалд сөргөөр нөлөөлж, түүнийг эв эеэр шийдвэрлэх арга замыг хайсаар л байна.

Тиймээс дэлхийн улс орнуудын хөгжлийг хүний хөгжлийн үзүүлэлтээр, тухайлбал наслалт, боловсролын түвшин, эмнэлэгийн тусламжийн хүртээмж, нэг хүнд ноогдох дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээ, орлого, амьдарч, ажиллаж буй орчны аюулгүй байдал хангагдсан байдлаар нь үнэлэхийг оролдож байгаа нь улс орон, нийгэм, төрд учруулж байгаа аюул заналын эх үүсвэр нь хүмүүсийн амьдралын төлөөх хэт хувиа хичээсэн бодлогогүй ажиллагаа, хүний хөгжлийг хангах нь түүнийг зайлуулах нэг арга зам, хүний аюулгүй байдлыг хэрхэн хангаж байгаагаар нь улс орны хөгжлийн чадавхийг тодорхойлж болохыг харуулж байна.¹

¹ Гомбо С, Монгол улсын дотоод ба хүний аюулгүй байдлыг хангахад сөрөх тагнуулын шугамаар анхаарах асуудал, Тусгаар тогтнол сэтгүүл, УБ., 2010, 4 дэх тал

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүний хөгжлийн 1994 оны илтгэлд "хүний аюулгүй байдал" гэх ойлголтыг тусгасан ба энэхүү ойлголтын хүрээнд дор дурьдсан 7 зүйлд учирч буй хор хөнөөлийг багасгах талаар эрчимтэй ажиллахыг уриалсан юм. Үүнд:

1. Эдийн засгийн аюулгүй байдал
2. Хүнсний аюулгүй байдал
3. Эрүүл мэндийн аюулгүй байдал
4. Хүрээлэн буй орчны аюулгүй байдал
5. Хувь хүний аюулгүй байдал
6. Нийгмийн аюулгүй байдал
7. Улс төрийн аюулгүй байдал зэрэг болно.¹

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал 1994 онд батлагдсанаас хойш багагүй хугацаа өнгөрч, улмаар улс орны гадаад, дотоод орчны нөхцөл байдалд гарсан өөрчлөлтүүдийг харгалзан үзэл баримтлалыг шинэчлэн боловсруулж 2010 оны 7 дугаар сард баталсан билээ.

Үндэсний аюулгүй байдлын 1994 оны үзэл баримтлалаар "Нийгэм төрийн аюулгүй байдал, хүний эрх, эрх чөлөөний, экологийн аюулгүй байдлыг тус тусад нь Үндэсний аюулгүй байдлын бүрэлдэхүүн хэсэг болгон авч үзэж байсан бол 2010 оны шинэ баримтлалаар нийгэм төрийн аюулгүй байдлыг нэгтгэн "Дотоод аюулгүй байдал", хүний аюулгүй байдлыг экологийн аюулгүй байдалтай хамтатган хүний эрүүл, аюулгүй орчинд ажиллаж, амьдрах нөхцөлтэй холбон цогц байдлаар оруулсан нь иргэн төвтэй, иргэний ардчилсан нийгэм цогцлон байгуулахаар заасан Үндсэн хуулийн үзэл санаанд нийцүүлсэн гэж үзэж болно.^{1 2}

Монгол улсын Үндсэн хуулийн хоёрдугаар бүлгийн 16 дугаар зүйлийн 2-т "эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй"; 6-д "эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж авах эрхтэй. Иргэдэд эмнэлгийн төлбөргүй тусламж үзүүлэх болзол. журмыг хуулиар тогтооно"; 17-д "төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй. Хүний эрх, нэр төр, алдар хүнд, улсыг батлан хамгаалах, үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журмыг хангах зорилгоор задруулж үл болох төр, байгууллага, хувь хүний нууцыг хуулиар тогтоон хамгаална"³ гэж хүний эрх, эрх чөлөөний талаар заасан нь хүний аюулгүй байдлыг хангах эрх зүйн үндэслэлийн нэг болж байна.

¹ Бямбадорж Ж ред, Хүний эрхийн товч тайлбар, УБ., 2012, 199 дэх тал.

² Гомбо С, Монгол улсын дотоод ба хүний аюулгүй байдлыг хангахад сөрөх тагнуулын шугамаар анхаарах асуудал, Тусгаар тогтнол сэтгүүл, УБ., 2010, 3 дахь тал

³ Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 2, 6, 17 дахь хэсэг. Төрийн мэдээлэл. 1992.№01.

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалм нэгдүгээр зүйлийн 1.2.3-д “...Үндэсний аюулгүй байдлын бодлого цогц байх бөгөөд Монгол Улсын "Оршин тогтнохуйн аюулгүй байдал", “Эдийн засгийн аюулгүй байдал”, “Дотоод аюулгүй байдал”, “Хүний аюулгүй байдал”, “Хүрээлэн байгаа орчны аюулгүй байдал”, “Мэдээллийн аюулгүй байдал” харилцан уялдаатай хангагдсанаар Үндэсний аюулгүй байдал баталгаажна” хэмээн заасан байдаг.

Хүний аюулгүй байдал нь үндэсний аюулгүй байдлын салшгүй нэг хэсэг бөгөөд энэ тухай онолын үзэл баримтлалыг авч үзвэл иргэдийн аюулгүй байдлыг хангах нь төрийн үүрэг юм.^{1 2}

Монгол Улсын Их хурлын 48-р тогтоолоор батлагдсан Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын гуравдугаар зүйлийн 3.4-т “Хүний аюулгүй байдал”-ыг үндэсний аюулгүй байдлын бүрэлдэхүүн хэсэг мөн гэж үзээд “Монгол хүний эрүүл, аюулгүй амьдрах таатай орчин, нөхцөлийг бүрдүүлэх, хүнсний аюулгүй байдлыг хангах, амьдрах орчин, орон байрны аюулгүй нөхцөлийг баталгаажуулах, гэмт хэрэг, халдлагын золиос болохоос хамгаалах нь хүний аюулгүй байдлыг хангах үндэс мөн.” гэж тодорхойлжээ.³

Хилийн аюулгүй байдалд учирч болзошгүй аюулын тухай бидний төсөөлөлд ихээхэн өөрчлөлт орж, уламжлалт аюулын зэрэгцээ үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэг, хүний наймаа, олон улсын терроризм, цөмийн түүхий эд материал дамжуулан худалдаалах, үйлдвэрлэх оролдлого, байгалийн гамшигт үзэгдэл, дэлхийн цаг уурын дулаарал, хүний амьдрах орчны бохирдол, нэн халдварт өвчний тархалт, олныг хамарсан ядуурал, эмх замбараагүй дүрвэлт зэрэг улс орны хил хязгаараар зааглагддаггүй уламжлалт бус аюулын хүрээ өргөжиж байгаагийн дотор мансууруулах бодисын зөөвөр дэлхий нийтийг хамарсан шинэ аюул занал болон хувирч байна.

Улс орны эдийн засгийн хямрал, ажилгүйдэл, ядуурал, банк санхүүгийн өрийн дарамттай холбоотойгоор хүний амин чухал ашиг сонирхол хангагдахад хүндрэлтэй болж, хүн өөрийн аюулгүй байдлаа хангах зорилгоор улсын хилийн аюулгүй байдалд халдсан үйлдлийг хийх болсон байна.

Хил орчмын нутаг дэвсгэрт оршин суугаа иргэдийн аюулгүй байдалд анхаарал хандуулж, хязгаар нутгийн хөгжил дэд бүтэц, иргэдийн амьжиргааг дээшлүүлэх, ажилгүйдлийг бууруулах, хүн ам зүйн бодлого эрүүл мэндийг хамгаалах арга хэмжээг авснаар хил орчмын нутагаас төв суурин руу чиглэсэн их нүүдлийг зогсоож, хилийн бүс зурвас эзэнгүйдэх, иргэдээс амар хялбар

¹ Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, 2010 он, УИХ-ын 48-р тогтоол.

• Тогтох Ш, Пүрэвбаасан В, Хүний аюулгүй байдал. түүнд нөлөөлж буй хүчин зүйлүүд, аюулгүй байдлыг хангах арга зам, Хууль сахиулахуйн удирдлага, УБ., 2018, 29 дэх тал.

³ Бямбадорж Ж ред, Хүний эрхийн товч тайлбар, УБ., 2012, 200 дахь тал.

аргаар мөнгө олох зорилгоор хил дамнасан наймаа, хар тамхи мансууруулах бодисын тээвэрлэгч болох зэрэг эрсдэлүүд багасах боломжтой юм.

ДҮГНЭЛТ: Хилийн аюулгүй байдал нь төр, нийгэм, иргэдийн язгуур ашиг сонирхолыг хилийн орон зайд хангах замаар үндэсний хийгээд, улс хоорондын аюулгүй байдлыг хангах тогтвортой урьдчилсан нөхцөлийг бүрдүүлэхэд оршино.

Үүнтэй холбогдуулан хил орчмын нутаг дэвсгэрт гарч болох аюулуудыг арилгах, саармагжуулах зорилгоор төрөөс авч хэрэгжүүлж байгаа улс төр, нийгмийн шинжтэй арга хэмжээнүүдийн зэрэгцээ эдийн засаг, хун ам зүй, зэргэлдээ улсаас манай улсын нутаг дэвсгэрт үйлдэж болзошгүй шашин-соёлын түрэмгийлэл, хил дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн бүлэглэл, гадаадын террорист байгууллагуудын уйл ажиллагаа, улсын хил, хил орчмын нутаг дэвсгэрт явагдаж буй нийгэм, улс төрийн байдал, хар тамхины наймааны зөөвөр зэрэг сөрөг үзэгдлүүдийн үндсийг судлан, тэдгээрээс урьдчилан сэргийлэх, гарсан тохиолдолд таслан зогсоох талаар төрөөс тусгайлан бодлого боловсруулж, хүний аюулгүй байдлыг хангах /хил орчмын нутаг дэвсгэрт оршин суугч иргэдийн/ талаар тодорхой арга хэмжээг дэс дараатайгаар авч хэрэгжүүлэх асуудал онцгой чухлаар тавигдаж байна.

УЛСЫН ХИЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАМГААЛАЛТЫН АРГААР ХАНГАХ НЬ

Н.ГАНТӨМӨР

ХСИС-ийн Хууль сахиулах удирдлагын академийн
8042 дугаар дамжааны суралцагч, хошууч;

В.Пүрэвбаасан

ХСИС-ийн Хууль сахиулахын удирдлагын академийн
Хилийн албаны удирдлага, стратегийн профессорын
багийн дэд профессор, хурандаа

Товч агуулга:Тус илтгэлээр улсын хилийн аюулгүй байдлын тухай ойлголт, түүний мөн чанар, түүнд нөлөөлөх хүчин зүйл, тэдгээрийн харилцан хамаарал, хилийн аюулгүй байдлыг хамгаалалтын аргаар хангах тухай авч үзлээ.

Түлхүүр үг:Монгол улсын тусгаар тогтнол, Хилийн аюулгүй байдал, Улсын хил хамгаалалт.

Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, газар нутгийн бүрэн бүтэн байдал нь улсын хилийн найдвартай хамгаалалттай шууд холбоотой. Улсын хил хамгаалалтыг өргөн утгаар нь улсын хилийн аюулгүй байдлыг хангах явдал гэж ойлгож болно.